



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 01 сарын 24 өдөр

Дугаар АМ2

Улаанбаатар хот

Гудамжны нэр олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дахь хэсэг, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2010 оны 6/48 дугаар тогтоол, дүүргийн Засаг даргын 2017 оны 01/136 тоот албан бичгээр өргөн мэдүүлсэн саналыг тус тус үндэслэн Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сонгинохайрхан дүүргийн 22 дугаар хорооны хүн амын суурьшлыг харгалзан нутаг дэвсгэрийн гэр хорооллын шинээр бий болсон зарим гудамжны нэрийг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллахыг дүүргийн Засаг дарга /Ж.Сандагсүрэн/-д даалгасугай.



Б.МӨНХЦЭЦЭГ

1180100033

Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн
2017 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 112
дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



22-р хороо

Тус хороонд шинээр бий болсон гудамжуудыг Зам анги 1-15 дугаар гудамж, Тахилт радио, телевизийн гудамж, Бөөр булаг 1-8 дугаар гудамж, Баян-Уулын 1-18 дугаар гудамж, Баянтуруун 1-79 дүгээр гудамж, Тахилт хотхон, Тахилтын хөндийн гудамж, Бага тахилтын айлууд гэж нэрлэх.